# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Увс аймгийн Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/121/НА-СТА-ТШЗ



| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2026 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Аудитор: Т.Золоо<br>Утас: 70453799, Цахим хаяг: zoloot@audit.gov.mn |



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт....3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга....12
   - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....12
   - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин....13
   - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....13
   - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт....13
   - 3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэтүүд....14
4. Аудитын тайлан....15
   - 4.1 Ерөнхий зүйл ....15
   - 4.2 Материаллаг байдал ....16
   - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....16
   - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....16
   - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....17
   - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....17
5. Аудитын илрүүлэлт ....17


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| | |

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026.02.25 № УВА-2026/121/НА-СТА-ТШ3
танай______________-ны №_________________-т

ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050445

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 1525010041

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

*/Төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **151,570,342.65** | **61,541,834.82** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 102,951,113.42 | 10,770,228.88 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 102,951,113.42 | 10,770,228.88 |
| **3121** | **Төгрөг** | 102,951,113.42 | 10,770,228.88 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 102,951,113.42 | 10,770,228.88 |
| **33** | **АВЛАГА** | 935,028.19 | 00.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 935,028.19 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 47,684,201.04 | 50,771,605.94 |
| **354** | **Хангамжийн материал** | 47,684,201.04 | 50,771,605.94 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,292,700.00 | 1,640,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 11,337,500.00 | 8,089,200.00 |
| 35460 | Хүнсний материал | 12,125,131.00 | 16,460,514.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 20,928,870.04 | 24,581,691.94 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,272,674,148.90** | **2,146,101,615.33** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,272,674,148.90 | 2,146,101,615.33 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,213,273,148.90 | 2,087,110,615.37 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,147,254,197.27 | 2,164,485,197.27 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -375,364,919.49 | -441,470,295.24 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 50,000,000.00 | 50,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -29,166,666.48 | -37,499,999.76 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 487,325,824.35 | 437,673,724.65 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -238,895,051.06 | -242,383,310.62 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 186,932,617.56 | 168,527,608.28 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -115,043,448.74 | -105,085,654.08 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 97,019,500.00 | 93,462,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -45,810,415.99 | -49,620,666.61 |
| 39217 | Ном | 49,021,511.48 | 49,021,511.48 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 59,401,000.00 | 58,990,999.96 |
| 39301 | Програм хангамж | 1,180,000.00 | 1,180,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -665,000.00 | -1,075,000.04 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 58,886,000.00 | 58,886,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,424,244,491.55** | **2,207,643,450.15** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **26,492,500.00** | **67,751,313.83** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 26,492,500.00 | 67,751,313.83 |
| **413** | **Өглөг** | 26,492,500.00 | 67,751,313.83 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 67,751,313.83 |
| **4136** | **Бусад өглөг** | 26,492,500.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 26,492,500.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,397,751,991.55** | **2,139,892,136.32** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,397,751,991.55 | 2,139,892,136.32 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 764,402,767.34 | 764,402,767.34 |
| 51101 | Өмч:  - төрийн | 764,402,767.34 | 764,402,767.34 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 809,172,605.48 | 551,695,229.83 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 809,172,605.48 | 809,555,085.06 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -257,859,855.23 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 824,176,618.73 | 823,794,139.15 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,424,244,491.55** | **2,207,643,450.15** |

## 2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,839,781,327.70** | **2,910,297,844.12** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **365,344,127.70** | **40,113,444.12** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 365,344,127.70 | 40,113,444.12 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,853,900.00 | 13,890,622.22 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,853,900.00 | 4,156,400.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 9,734,222.22 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,474,437,200.00** | **2,870,184,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,185,816,900.00 | 2,637,204,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,185,816,900.00 | 2,637,204,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 288,620,300.00 | 232,980,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 288,620,300.00 | 232,980,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,567,434,195.32** | **3,168,157,699.35** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,567,434,195.32** | **3,168,157,699.35** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,503,077,028.32 | 3,075,680,959.35 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,697,352,246.81 | 2,120,114,037.14 |
| 210101 | Үндсэн цалин | 1,014,862,250.81 | 1,184,639,804.14 |
| 210102 | Нэмэгдэл | 613,570,226.00 | 799,188,079.47 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 57,946,621.00 |
| 210104 | Урамшуулал | 68,919,770.00 | 78,339,532.53 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 210,319,417.98 | 265,675,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 144,599,225.31 | 179,620,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,011,673.35 | 21,513,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,816,490.19 | 10,756,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,019,972.53 | 10,756,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,872,056.60 | 43,027,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 284,745,025.89 | 293,446,016.05 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,865,470.96 | 23,301,735.05 |
| 210302 | Түлш, халаалт | 270,879,554.93 | 270,144,281.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 34,298,614.00 | 38,187,416.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 19,361,750.00 | 17,139,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,846,364.00 | 6,947,566.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,090,500.00 | 14,100,750.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 92,360,819.50 | 134,951,127.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 204,300.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 92,156,519.50 | 134,951,127.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,000,000.00 | 3,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 3,600,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,008,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,008,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 19,428,070.30 | 23,322,429.99 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,853,900.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 15,574,170.30 | 23,322,429.99 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 153,564,833.84 | 196,384,233.17 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,013,979.11 | 30,687,299.60 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 128,550,854.73 | 165,696,933.57 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 64,357,167.00 | 92,476,740.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 64,357,167.00 | 92,476,740.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 64,357,167.00 | 92,476,740.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **272,347,132.38** | **-257,859,855.23** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **272,347,132.38** | **-257,859,855.23** |

### 2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,478,291,100.00** | **2,874,340,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,853,900.00** | **4,156,400.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,853,900.00 | 4,156,400.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 3,853,900.00 | 4,156,400.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,853,900.00 | 4,156,400.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,474,437,200.00** | **2,870,184,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,185,816,900.00 | 2,637,204,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,185,816,900.00 | 2,637,204,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 288,620,300.00 | 232,980,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 288,620,300.00 | 232,980,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,444,619,169.39** | **2,923,349,784.54** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,444,619,169.39** | **2,923,349,784.54** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,380,262,229.39** | **2,840,102,804.54** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,698,012,600.26 | 2,119,179,008.95 |
| 210101 | Үндсэн цалин | 1,059,334,801.00 | 1,183,704,865.95 |
| 210102 | Нэмэгдэл | 568,639,239.26 | 799,188,079.47 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 57,946,621.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 70,038,560.00 | 78,339,442.53 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 210,594,092.72 | 265,675,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 142,361,292.72 | 179,620,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,058,200.00 | 21,513,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,529,100.00 | 10,756,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,529,100.00 | 10,756,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 34,116,400.00 | 43,027,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 285,620,300.00 | 229,380,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,740,745.07 | 21,785,800.70 |
| 210302 | Түлш, халаалт | 270,879,554.93 | 207,594,199.30 |
| **2105** | **Нормативт зардал** | 94,004,073.00 | 135,096,750.00 |
| 210502 | Хоол, хүнс | 94,004,073.00 | 135,096,750.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,000,000.00 | 3,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 3,600,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 27,306,147.41 | 32,177,172.59 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,853,900.00 | 3,740,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 23,452,247.41 | 28,437,172.59 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 61,725,016.00 | 54,994,173.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 45,434,316.00 | 44,621,473.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,290,700.00 | 10,372,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **64,356,940.00** | **83,246,980.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 64,356,940.00 | 83,246,980.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 64,356,940.00 | 83,246,980.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **33,671,930.61** | **-49,008,984.54** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **26,492,500.00** | **43,171,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **26,492,500.00** | **43,171,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 26,492,500.00 | 43,171,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 26,492,500.00 | 43,171,900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-26,492,500.00** | **-43,171,900.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 7,179,430.61 | -92,180,884.54 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 95,771,682.81 | 102,951,113.42 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 102,951,113.42 | 10,770,228.88 |

## 2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 764,402,767.34 | 824,219,963.37 | 586,842,304.14 | 2,175,465,034.85 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **764,402,767.34** | **824,219,963.37** | **586,842,304.14** | 2,175,465,034.85 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -31,427,151.80 | -31,427,151.80 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **764,402,767.34** | **824,176,618.73** | **809,172,605.48** | 2,397,751,991.55 |
| D01 | **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **764,402,767.34** | **824,176,618.73** | **809,172,605.48** | 2,397,751,991.55 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 382,479.58 | 382,479.58 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **764,402,767.34** | **824,176,618.73** | **809,555,085.06** | 2,398,134,471.13 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -382,479.58 | 00.00 | -382,479.58 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -257,859,855.23 | -257,859,855.23 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **764,402,767.34** | **823,794,139.15** | **551,695,229.83** | 2,139,892,136.32 |

## 2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 102951113.42 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,775,772,900.00 | 2,733,541,684.54 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,775,772,900.00 | 2,733,541,684.54 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,695,697,600.00 | 2,650,294,704.54 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,160,145,300.00 | 2,119,179,008.95 |
| 210101 | Үндсэн цалин | 1,296,062,000.00 | 1,183,704,865.95 |
| 210102 | Нэмэгдэл | 811,230,400.00 | 799,188,079.47 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 57,946,621.00 |
| 210104 | Урамшуулал | 52,852,900.00 | 78,339,442.53 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 270,018,200.00 | 265,675,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 183,612,400.00 | 179,620,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 21,601,500.00 | 21,513,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,800,700.00 | 10,756,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,800,700.00 | 10,756,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 43,202,900.00 | 43,027,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 143,619,300.00 | 135,096,750.00 |
| 210502 | Хоол, хүнс | 143,619,300.00 | 135,096,750.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 31,224,300.00 | 32,177,172.59 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,740,000.00 | 3,740,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 27,484,300.00 | 28,437,172.59 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 90690500.00 | 98166073.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 80,317,800.00 | 87,793,373.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,372,700.00 | 10,372,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 80075300.00 | 83246980.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 80,075,300.00 | 83,246,980.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 80,075,300.00 | 83,246,980.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,640,944,400.00 | 2,641,360,800.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,637,204,400.00 | 2,637,204,400.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,637,204,400.00 | 2,637,204,400.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 3,740,000.00 | 4,156,400.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,740,000.00 | 4,156,400.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 102,951,113.42 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 10,770,228.88 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 61.00 | 61.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 04.00 | 04.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 33.00 | 33.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 22.00 | 22.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 02.00 | 02.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **61.00** | **61.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 37.00 | 37.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 22.00 | 22.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 02.00 | 02.00 |

## 2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **232,980,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **232,980,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 232,980,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 229,380,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,785,800.70 |
| 210302 | Түлш, халаалт | 207,594,199.30 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,600,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 232,980,000.00 |
| 131101 | Орон нутгийн төсвөөс | 232,980,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд бага дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих ажлыг мэргэжлийн болон захиргааны удирдлагаар хангах, хүүхэд хамгааллын хамтын ажиллагааг сайжруулж, эцэг, эх олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн эрүүл таатай орчин бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 148,743.9 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт***

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 102,951.1 | 10,770.2 | -92,180.9 |
| Авлага | 935.0 | 0.00 | -935.0 |
| Бараа материал | 47,684.2 | 50,771.6 | 3,087.4 |
| Үндсэн хөрөнгө | 2,272,674.2 | 2,146,101.7 | -126,572.5 |
| **Нийт хөрөнгө** | **2,424,244.5** | **2,207,643.5** | **-216,601.0** |
| Өр төлбөр | 26,492.5 | 67,751.4 | 41,258.9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,397,752.0 | 2,139,892.1 | -257,859.9 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,424,244.5** | **2,207,643.5** | **-216,601.0** |

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь тайланд онд 10,770.2 мянган төгрөг болж 92,180.9 мянган төгрөг болж буурсан байна.

Авлага данс 935.0 мянган төгрөгөөр буурсан ч авлагын үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 50,771.6 мянган төгрөг болж 3,087.4 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, бусад хангамжийн материал өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 2,146,101.7 мянган төгрөг болж 126,572.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 16,679.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 20,931.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, тайлант онд 164,885.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцож, 93,507.5 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 67,751.4 мянган төгрөг болж өссөн нь 12 сард хоолны зардал тавигдаагүй мөн түлш халаалтын зардал дутуу өгсөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,139,892.1 мянган төгрөг болж 257,859.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,032,785.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 267,927.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 699,541.2 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 2,368,190.8 мянга, орон нутгийн төсвөөс 232,980.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 407,582.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,798,324.1 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,733,541.7 мянган төгрөг буюу 76.4 хувийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байр ашиглалтын үйлчилгээ /80226/ | 2,788.0 | 2,750.7 | 37.3 | 98.7% |
| 2 | Хүүхэд хамгаалал /80233/ | 2,867.7 | 2,687.7 | 180.0 | 93.7% |
| 3 | Сургалт семинар /80312/ | 1,637.1 | 1,588.3 | 48.7 | 97.0% |
| 4 | Эрүүл мэндийг дэмжих /81605/ | 3,052.4 | 3,052.4 | 0 | 100% |
| 5 | Үдийн цай хөтөлбөр | 90.529.9 | 83,246.9 | 7,282.9 | 100% |
| 6 | Дотуур байрны үйлчилгээ /81806/ | 487,007.9 | 438,177.1 | 48,830.7 | 90.0% |
| 7 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин /81816/ | 44,972.5 | 44,972.5 | 0 | 100% |
| 8 | Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх/81823/ | 12,096.3 | 12,096.3 | 0 | 100% |
| 9 | Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр /81827/ | 34,268.8 | 31,544.4 | 2,724.3 | 92.1% |
| 10 | Боловсролын стандарт, сургалтын хэвийн үйл ажиллагаа /81834/ | 2,053478.0 | 2,053,251.1 | 0 | 100% |
| 11 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа /81835/ | 49,201.7 | 46,672.9 | 2,493.7 | 94.9% |
| 12 | Сурах бичгийн түрээс /81848/ | 3,740.0 | 3,740.0 | 0 | 100% |
| 13 | Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх /81875/ | 10,293.8 | 9,761.2 | 0 | 100% |
| 14 | Дээд шатнаас хувиарласан | 2,390.0 | 0.0 | 2,390.0 | 0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5, 2.6-д харуулав.

**Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн**

Программын судалгааг хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

| Д/Д | Программ, лиценз нийлүүлсэн байгууллагын нэр | Санхүүгийн тайланд бүртгэлтэй эсэх /тийм, үгүй/ | Зориулалт | Тайланд онд гэрээний дагуу төлсөн төлбөр |
|---|---|---|---|---|
| 1 | Санхүүгийн тооцоолох ХХК | тийм | Санхүү, нягтлан бодох бүртгэл | 440.0 |
| 2 | Мишээлт гүн ХХК | үгүй | Архив, бичиг хэрэг | 300.0 |
| 3 | Санхүүгийн тооцоолох ХХК | тийм | Няравын орлого зарлага бүртгэх | 440.0 |
| | Нийт дүн | | | 1,180.0 |

Унаа, хоол, сургалт семинарын орон тооны судалгааг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Төсөвлөсөн | Гүйцэтгэл | Зөрүү | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Унаа, хоолны зардал | 0.00 | 57,946.6 | -57,946.6 | Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/554 дугээр албан бичгийн дагуу хоолны зардлыг 5000 төгрөгөөр тооцоон олгож эхэлсэн. |
| 2 | Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал | 1,637.1 | 1,588.3 | 48.8 | Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусадсаны дагуу багшийн хөгжлийн зардлаас багш нарыг 3 удаагийн сургалтад хамруулсан байна. |
| 3 | Гадаад томилолт, арга хэмжээ | 0.00 | 0.00 | 0.00 | Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна. |
| 4 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал | 0.00 | 0.00 | 0.00 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна. |
| 5 | Орон тоо | 61 | 61 | 0.00 | Бүтэц орон тоонд өөрчлөлт ороогүй байна. |
| 7 | Хэвлэл мэдээлэл | 0.00 | 0.00 | 0.00 | Хэвлэл мэдээлэлтэй холбоотой зардал гараагүй байна. |

**3.5.3 Орон нутгийн төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 229,380.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 3,600.0 мянган төгрөгийг төсөвлөн гүйцэтгэлээр 232,980.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

***3.5.4* Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургууль нь хоолны материалын тендер худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж шалгарсан 7 аж ахуй нэгж, иргэнтэй гэрээ байгуулан 135,096.7 мянган худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Золоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 2,567,434.2 мянган төгрөгийн 1 хувиар буюу 25,674.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,168,157.7 мянган төгрөгийн 1 хувиар буюу 31,681.5 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 25,345.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаандаа оруулсан 175, хугацаа хоцроон байршуулсан 2, мэдээлээгүй 1, мэдээлэх хугацаа болоогүй 5 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн бөгөөд аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,169.5 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 58 дугаар албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn систем бүртгэсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 1 | 1,169.5 | 1 | 1,169.5 | 100% |
| **Нийт дүн** | **1** | **1,169.5** | **1** | **1,169.5** | **100%** |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Т.ЗОЛОО/

2026 оны 02 сарын 25-ны өдөр